

ЭДИЙН ЗАСГИЙГ СЭРГЭЭН ХӨГЖҮҮЛЖ, ТОГТВОРТОЙ ХӨГЖЛИЙГ БИЙ БОЛГОХ  
 “БАЯЛАГ БҮТЭЭГЧ-БАЯНХОНГОР” ХӨТӨЛБӨРИЙН 2023 ОНЫ  
 ЖИЛИЙН ЭЦСИЙН ХЭРЭГЖИЛТ  
 (Шинэжинст сум)

2023 оны 12 дугаар сарын 10

Залаа

Д/д	Зорилт	Арга хэмжээ	Хэрэгжих хугацаа	Зарцуулсан хөрөнгийн хэмжээ, эх үүсвэр (сая төгрөг)	Зорилтот түвшин, үр дүнгийн үзүүлэлт	Хүрсэн түвшин, үр дүн	Хэрэгжилтийн хувь	Дээд шатны байгууллагын үнэлгээ
1	2	3	4	5	6	7	8	9
1	ХОЁР. ХӨДӨӨ АЖ АХУЙН ИННОВАЦИЙГ НЭВТРҮҮЛЖ, КЛАСТЕРИЙН ЗОХИОН БАЙГУУЛАЛТАД ОРУУЛАХ	2.2. Ашиг шимийн чиглэлээр нь төрөлжүүлэн хөгжүүлэх бүс нутгуудад Монгол оронд дасан зохицсон баталгаажсан үүлдэр, омгийн малаас шилэн сонгосон цөм сүргийн сайжруулагчийг үржилд ашиглан ашиг шимийг нь нэмэгдүүлнэ.	2022 - 2024	14 сая		Хүнс, Хөдөө аж ахуй Хөнгөн үйлдвэрийн яамны захиалгаар Баянбулаг омгийн хонин сүргээс бойжуулсан шүдлэн хуц 30 толгой, Залаажинст-Эдрэн үүлдрийн ямаан сүргээс бойжуулсан өсвөр 30 толгой хээлтүүлэгчийг хүлээн авч малчдад гэрээлэн хээлтүүлэгт ашиглаж байна. Мөн тогтвортой ноолуур төслийн 18 сая төгрөгийн санхүүжилтээр 130 толгой Залаажинст-Эдрэн үүлдрийн цөм сүргийн хээлтүүлэгчийг худалдан авч суурилан маллуулж байна. Улсын их хурлын даргын санаачилгаар малын чанарыг сайжруулах төслийн хүрээнд 25 толгой Баянбулаг омгийн хонин сүргээс бойжуулсан 25 толгой өсвөр хээлтүүлэгчийг хүлээн авч тээвэрлэн авчирч малчдад гэрээгээр ашиглуулж байна.	100%	100%
2	ГУРАВ. ТӨР, ХУВИЙН ХЭВШЛИЙН ТҮНШЛЭЛ, ХАМТЫН АЖИЛЛАГААНЫ	3.1. Жижиг, дунд үйлдвэрлэлийг дэмжсэн, бизнесийг хөгжүүлэхэд	2022 - 2024	70000, Залаа шинэ-эргэлт хоршоо		Жижиг дунд үйлдвэрлэлийг хөгжүүлэх, бизнес эрхлэгчдийг чадавхжуулах зорилгоор 1-р улиралд Баянхонгор аймагт зохион байгуулсан сургалтад "Залаа шинэ-эргэлт" хоршооны 1 гишүүнийг, BEST хөтөлбөртэй хамтран зохион байгуулсан "Сумандаа бизнес төсөл хэрхэн бичих вэ"	90%	90%

1	2	3	4	5	6	7	8	9
	МЕНЕЖМЕНТИЙГ САЙЖРУУЛАХ	чиглэгдсэн бодлого, эрх зүйн орчныг сайжруулж, бизнес эрхлэгчдийг чадавжуулах, сургаж дадлагажуулах, судалгаа мэдээллээр хангах, үйл ажиллагааг нь сурталчлах замаар бизнесийн таатай орчныг бий болгоно.				сургалтад жижиг, дунд үйлдвэрлэл, бизнес эрхлэх сонирхол бүхий 22 иргэнийг, Тогтвортой ноолуур төслөөс Баянхонгор аймагт зохион байгуулсан "Хоршооны үнэлгээ, хяналт хийх сургагч багш бэлтгэх" сургалтад "Цармын цагаан сувд" хоршооны нягтлан бодогч Г.Цэдэвсүрэнг тус тус хамруулсан. Хяналт тавих орон тооны бус зөвлөлийн бүрэлдэхүүн 11 сард Хоршоо хөгжүүлэх сангийн хөнгөлөлттэй зээлд хамрагдсан "Цармын цагаан сувд" хоршоо, "Бат богд дулаан" ХХК, Ж.Отгонбаяр, Ш.Болормаа, Ч.Булганжаргал нарын зээлийн ашиглалт, бизнесийн үйл ажиллагаатай танилцаж бүтээгдэхүүн, үйлчилгээгээ чанаржуулах, нэмэгдүүлэх, санхүү, төсөв тооцоогоо хянах талаар зөвлөгөө, мэдээллээр хангаж хоршоо хөгжүүлэх сангийн шинэчлэгдсэн журам, Бэст хөтөлбөрөөс эрхлэн гаргадаг жижиг дунд бизнесийн зардлын бүртгэл, гарын авлага материал тараав.		

**“ЗӨВ АМЬДРАЛ” ДЭД ХӨТӨЛБӨР**

Д/д	Зорилт	Арга хэмжээ	Хэрэгжих хугацаа	Зарцуулсан хөрөнгийн хэмжээ, эх үүсвэр (сая төгрөг)	Зорилтот түвшин, үр дүнгийн үзүүлэлт	Хүрсэн түвшин, үр дүн	Хэрэг жил тийн хувь	Дээд шатны байгууллагын үнэлгээ
1	2	3	4	5	6	7	8	9
1	1.1. Өсвөр үе болон иргэд, төрийн албан хаагчдын эрх зүйн мэдлэг, хандлагыг дээшлүүлэх	1.1.4. Цахим орчинд “Би архи хэрэглэдэггүй” challenge өрнүүлэх	2021 - 2024			Цахим орчинд "Би архи хэрэглэдэггүй", "ойлгоё хүндэлье", "архигүй тэмдэглээ" зэрэг шторкуудыг цагдаагийн хэсэгтэй хамтран аялуулсан. Сумын гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зөвлөлөөс "Архигүй цагаан сар" уриалга гаргаж, иргэдэд мэдээлсэн. Мөн "архигүй шинэ жил" уриалгад байгууллага хамт олноороо нэгдэж эхэлсэн. Сургалт сурталчилгаа нөлөөллийн ажлыг багуудын Иргэдийн Нийтийн хуралд хариуцах албан хаагчид тухай бүр тавьж,	70%	50%



1	2	3	4	5	6	7	8	9
	замаар архийг жигших сэтгэл зүйтэй болгох сургалт, сурталчилгаа нөлөөллийн ажлыг тогтмол зохион байгуулах					сэрэмжлүүлж ажилласан бөгөөд давхардсан тоогоор 1000 гаруй иргэдэд архины хор уршиг, гэмт хэргийн тоо баримтуудыг сонсгож ажилласан.		
2	2.1. Архидан согтуурах, гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, хяналт тавих арга хэмжээг иргэд, гэр бүл, төрөл садан, хамт олон, төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуйн нэгжийн нэгдмэл хамтын үйл ажиллагаанд тулгуурлан зохион байгуулна.	2.1.1. Согтууруулах ундаа хэтрүүлэн хэрэглэж орчиндоо айдас төрүүлдэг, удаа дараа эрүүлжүүлэгддэг архины хамаарал бүхий иргэдийг “Жаргалтай амьдрал төв”-д холбон зуучилж, нийгэм, сэтгэл зүйн үйлчилгээнд хамруулах.	2021 - 2024			Согтууруулах ундаа хэтрүүлэн хэрэглэж орчиндоо айдас төрүүлдэг, удаа дараа эрүүлжүүлэгддэг архины хамаарал бүхий иргэдийг “Жаргалтай амьдрал төв”-д холбон зуучилж, нийгэм, сэтгэл зүйн үйлчилгээнд хамруулах зорилтын хүрээнд 2023 онд жаргалтай төвд нэг ч иргэн хамруулаагүй байна. Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр цагдаагийн хэсэг гарын авлага материал тараах, хууль эрх зүйн мэдээллийг багийн иргэдийн нийтийн хурлуудаар хийж 510 иргэнд хүргэж ажилласан байна.	90%	50%
3		2.1.3. Архинд донтох өвчтэй хүн болон түүний гэр бүлийнхэнд эрүүл мэнд,	2021 - 2024			Архинд донтох өвчтэй хүн болон түүний гэр бүлийнхэнд эрүүл мэнд, сэтгэл зүйн зөвлөгөө өгөх, дэмжлэг үзүүлэх үйл ажиллагааг өргөжүүлж, энэ чиглэлээр гэр бүл, төрөл садан, хамт олны нөлөөлөл, үүрэг хариуцлагыг нэмэгдүүлэх чиглэлээр арга хэмжээ зохион байгуулах чиглэлээр 1 иргэнийг сонгож ажилласан бөгөөд сэтгэл зүйн зөвлөгөөг	70%	50%

1	2	3	4	5	6	7	8	9
		сэтгэл зүйн зөвлөгөө өгөх дэмжлэг үзүүлэх үйл ажиллагааг өргөжүүлж, энэ чиглэлээр гэр бүл, төрөл садан, хамт олны нөлөөлөл, үүрэг хариуцлагыг нэмэгдүүлэх чиглэлээр арга хэмжээ зохион байгуулах.				авч, 5 сарын хугацаанд архи уугаагүй, хэрэглээгүй үр дүнтэй байсан, сүүлийн үед давтан уулт явагдсан байна. Архины хамаарал бүхий иргэд нэг айлдаа бөөгнөрөн уух байдал гарсаар байгаа бөгөөд гэртээ ууж байгаа, хүний эрх гэдэг ойлголтыг авсан хүмүүсийг шууд эрүүлжүүлэх хууль эрх зүйд таарахгүй байгаа шалтгаанаас олон хоног даамжирч уух байдал гарч сөрөг үр нөлөөтэй байна. Ийм бөөгнөрдөг газруудаар эргүүл хяналтыг цагдаагийн хэсэг өдөр бүрийн давтамжтай хийж ажилладаг бөгөөд ах дүү, гэр бүл, хамаатан садантай нь хамтран ажилласны үр дүнд 12 иргэнд нөлөөллийн ажил сэтгэл зүйн зөвлөгөөг өгч ажилласнаар 6 иргэн архи уух байдлаас ангид байна.		
4	2.1. Архидан согтуурах, гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, хяналт тавих арга хэмжээг иргэд, гэр бүл, төрөл садан, хамт олон, төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуйн нэгжийн нэгдмэл хамтын үйл ажиллагаанд тулгуурлан зохион байгуулна.	2.1.4. Архины хамаарлаа шийдвэрлэсэн болон эрсдэл бүхий хүмүүсийг дахин архи уухаас өөрийгөө хамгаалах арга ухаанд сургах, ҮҮНД мэргэжлийн баг туслалцаа үзүүлэх ажлыг зохион байгуулах	2021 - 2024			Архины хамаарлаа шийдвэрлэсэн болон эрсдэл бүхий хүмүүсийг дахин архи уухаас өөрийгөө хамгаалах арга ухаанд сургах, үүнд мэргэжлийн баг туслалцаа үзүүлэх ажлыг зохион байгуулах ажлын хүрээнд сумын хэмжээнд гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зөвлөлөөс "Архигүй цагаан сар", "Архигүй шинэ жил" уриалгуудыг гаргаж ажиллаж байна. Архины хамаарал бүхий 12 иргэнд нөлөөллийн арга хэмжээг авч хэрэгжүүлсэн. Үүний 1 иргэн, 5 сарын дараа дахин уусан, бусад 11 иргэн ажил хөдөлмөр эрхлэн, 8 иргэн нь огт архи хэрэглээгүй 5-6 сар болж байна. Аймгийн гэр бүл, хүүхэд залуучуудын газраас 1 удаагийн нийтийн сургалт зохион байгуулж 68 иргэн хамрагдсан.	70%	50%



**ХОГ ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТИЙГ САЙЖРУУЛАХ АЙМГИЙН ХӨТӨЛБӨР**

Д/д	Зорилт	Арга хэмжээ	Хэрэгжих хугацаа	Зарцуулсан хөрөнгийн хэмжээ, эх үүсвэр (сая төгрөг)	Зорилтот түвшин, үр дүнгийн үзүүлэлт	Хүрсэн түвшин, үр дүн	Хэрэгжилтийн хувь	Дээд шатны байгууллагын үнэлгээ
1	2	3	4	5	6	7	8	9
1	ХОЁР. ХОГ ХАЯГДЛЫГ ЦУГЛУУЛАХ, ТЭЭВЭРЛЭХ, ДАХИН АШИГЛАХ, ДАХИН БОЛОВСРУУЛАХ, УСТГАХ ҮЙЛ АЖИЛЛАГААНД ОНОВЧТОЙ ТЕХНОЛОГИЙГ НЭВТРҮҮЛЖ, ХҮЛЭМЖИЙН ХИЙГ БУУРУУЛАХ	2.3. Сумдуудын хогийн төвлөрсөн цэгүүдийг хог хаягдлын хуульд заасны дагуу 3 дугаар зэрэглэлд үе шаттайгаар шилжүүлэх	2021 - 2025			Хог хаягдлыг цуглуулах, тээвэрлэх ажиллагааг тус сумын нутагт тусгай зөвшөөрөл эзэмшигч аж ахуйн нэгж "Эрдэнэмонгол" ХХК хэрэгжүүлж ажиллаж байна. "Эрдэнэмонгол" ХХК говийн усыг унданд хэрэглэдэггүй, цэвэр усыг зөөж унданд хэрэглэдэг учраас цэвэр ус, ундааны пябор савнууд ихээр гардаг учир түүнийг Улаанбаатар хот труу шууд ачиж тээвэрлэх замаар зайлуулж байна. Мөн сумын төвд иргэн Б нь 500 тн төмрийн хог хаягдал, иргэн Т нь 1тн хуванцар савыг цуглуулж ачуулах ажлыг гүйцэтгэж, нийт 601 тн хог хаягдлыг зайлуулсан.	70%	30%
2		2.6. Аймгийн төв болон сумдын оршуулгын газруудыг цэгцлэх, хөрсний бохирдлыг бууруулах, ногоон цэцэрлэгжүүлэх арга хэмжээг авч хэрэгжүүлэх	2021 - 2025			Сумын хэмжээнд оршуулгын газрыг цэгцлэх ажил хийгдэх шаардлагагүй, харин шарилын овооны орчмын дурсгалт газрыг тусгай зөвшөөрөл эзэмшигч аж ахуйн нэгжийн хариуцлагын хүрээнд хашаажуулж хамгаалах ажлыг "Сэкер ресорсус Монголиа" ХХК гүйцэтгэсэн. Хөрсний бохирдлыг бууруулах, ногоон цэцэрлэгжүүлэх арга хэмжээг авч хэрэгжүүлэх ажлын хүрээнд мод тарих ажлыг гүйцэтгэж, нийт 3800 мод таригдсан, үрээр 6500 ширхэг мод таригдсан байна.	90%	50%
3		2.8. Аймгийн нутаг дэвсгэрт	2021 - 2025			Сумын хэмжээнд аюултай хог хаягдлыг түр хадгалах, цуглуулах, тээвэрлэх, хадгалах, дахин боловсруулах, устгах үйл ажиллагаанд мэдээллийн технологид	30%	30%

1	2	3	4	5	6	7	8	9
		аливаа хог хаягдал нэн ялангуяа аюултай хог хаягдлыг түр хадгалах, цуглуулах, тээвэрлэх, хадгалах, дахин боловсруулах, устгах үйл ажиллагаанд мэдээллийн технологид суурилсан хяналтын тогтолцоог бүрдүүлэх				суурилсан хяналтын тогтолцоог бүрдүүлэх ажлын хүрээнд Эрүүл мэндийн төвийн аюултай хог хаягдлыг түр хадгалах цэгээс тээвэрлэн хүргэх аюултай хог хаягдлын устгах цэгийг шинээр байгуулж, тэмдэгжүүлж өгсөн. Ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигч 2 аж ахуйн нэгжид хяналт тавьж ажиллаж байгаа бөгөөд одоогоор аюултай хог хаягдал бүртгэгдээгүй байна.		
4	ГУРАВ. ХОГ ХАЯГДЛЫГ БАГАСГАХ, ЭДИЙН ЗАСГИЙН ЭРГЭЛТЭД ОРУУЛАХАД ЧИГЛЭСЭН МЕНЕЖМЕНТИЙН ТОГТОЛЦООГ БҮРДҮҮЛЖ, ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫГ ТАТАХ	3.3. Хог цэвэрлэх, цуглуулах, тээвэрлэх, ангилан ялгах, устгах, булшлах, ажиллагаанд хувийн хэвшлийн аж ахуйн нэгж байгууллагууд, иргэдийн оролцоог бодлогоор дэмжих, үйлчилгээний үнэ тарифыг зөвшилцөн тогтоох	2021 - 2025			Сумын Засаг даргын 2023 оны 03 дугаар сарын 15-ны өдрийн “Хог хаягдлыг цэвэрлэх ажлыг эрчимжүүлэх тухай”, Эхэнхавцгай багийн Засаг даргын 2023 оны 03 дугаар сарын 20-ны өдрийн “Хог хаягдлын их цэвэрлэгээг зохион байгуулах тухай” захирамжуудын хүрээнд нийтийн их цэвэрлэгээ 5 удаа зохион байгуулагдаж нийт 250 иргэн хамрагдан 25 тн хог хаягдал хогийн цэгт хүргэж ажилласан байна., золбин нохой устгал 2 удаа зохион байгуулагдан 100 гаруй нохой устгагдсан. Хог хаягдлын үнэ тариф тогтоож хууль зүйн яамаар батлагдсан тогтоолыг үндэслэн иргэнээс 1850000 төгрөг, аж ахуйн нэгжүүдээс 1114800 төгрөг төрийн санд төвлөрсөн байна.	90%	90%



1	2	3	4	5	6	7	8	9
5	ДӨРӨВ. ХАТУУ, ШИНГЭН ХОГ ХАЯГДЛААС ЯЛГАРЧ БУЙ ХҮЛЭМЖИЙН ХИЙ, ТҮҮНИЙ УУР АМЬСГАЛЫН ӨӨРЧЛӨЛТ, НИЙГЭМД ҮЗҮҮЛЭХ НӨЛӨӨЛЛИЙН ТАЛААРХ ОЛОН НИЙТИЙН ОЙЛГОЛТ, МЭДЛЭГИЙГ НЭМЭГДҮҮЛЭХ	4.1. Хог хаягдлыг бууруулах, ангилан ялгах талаар аймгийн иргэдийн мэдлэг, ухамсрыг дээшлүүлэх, дадал суулгах сургалт, сурталчилгааны ажлыг эрчимжүүлэх	2021 - 2025			Хог хаягдлыг бууруулах, ангилан ялгах талаар сумын багуудын ИНХ болон мэдээллийн цагуудаар нийт 6 удаа сургалт мэдээллийг хүргэж 560 гаруй иргэд хамрагдсан байна. Мөн сургуулийн 6 бүлгийн сурагчдад сургалт хийж нийт 160 сурагч хамрагдсан. Тусгай зөвшөөрөл бүхий аж ахуйн нэгж байгууллагуудад зөвлөмж хүргэснээр 4 ангилан ялгах сав байршуулагдсан.	90%	90%
6		4.5. Аймгийн хэмжээнд хоггүй шилдэг сум, баг болон аж ахуйн нэгж байгууллагыг шалгаруулах компани ажлыг жил бүр тогтмол зохион байгуулах	2021 - 2025			Хоггүй шилдэг сум, баг болон аж ахуйн нэгж байгууллагыг шалгаруулах компани ажлыг жил бүр тогтмол зохион байгуулах ажлын хүрээнд сумын Засаг даргын захирамжаар багийн өрх бүр өвөлжөө хаваржааны газрыг цэвэрлэх, байгууллага бүр нийтийн эзэмшлийн хуваарьтай газраа цэвэрлэж хэвших тухай захирамжилж өгсөн. "Хашаандаа Сагсны шийдтэй больё" уралдааны гол зорилго нь хашаа болон ойр орчимдоо хоггүй цэвэр байх, дасгал хөдөлгөөнтэй эрүүл чийрэг байх зорилго агуулсан уралдаан зарлагдсан. Шинэ жилээр шагнаж урамшуулахаар шийдвэрлэсэн.	90%	90%
7		4.6. Баянхонгор аймгийн Боловсролын газар, Байгаль орчин аялал жуулчлалын газар, Насан туршийн боловсрол,	2021 - 2025			Тус сумын Цэцэрлэгийн багш ажилчдаас бүрдсэн 5 хүн эко сургагч багшаар бэлтгэгдэн "Хүрэл гэгэ" өргөмжлөл хүртсэн бөгөөд Улаанбаттар хотод 2 удаа, гадаадад зорчиж туршлага судлах хүртлэх арга хэмжээнд оролцоод ирсэн. Цэцэрлэгийн хүүхдүүдийн 68 эцэг эхчүүдэд сургалт хийх нөлөөллийн ажлуудыг шат дараатай хийж ажиллаж байна.	90%	90%

1	2	3	4	5	6	7	8	9
		<p>Политехникийн коллеж, амйгийн хэмжээний бүх ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгүүдийг түшиглэн "Эко Баянхонгор" төслийн хүрээнд "Хог хаягдлын сургагч багш" бэлтгэж, сум, баг, хэсгийн ахлагч нарт иргэдтэй хамтран ажиллах чадавхийг бэхжүүлэх ажлыг үе шаттай зохион байгуулах</p>						
8	<p>ДӨРӨВ. ХАТУУ, ШИНГЭН ХОГ ХАЯГДЛААС ЯЛГАРЧ БУЙ ХҮЛЭМЖИЙН ХИЙ, ТҮҮНИЙ УУР АМЬСГАЛЫН ӨӨРЧЛӨЛТ, НИЙГЭМД ҮЗҮҮЛЭХ</p>	<p>4.7. Иргэд, олон нийтэд хог хаягдлын боловсрол олгох сургалт сурталчилгааны ажлын явц, тэргүүн туршлага болон судалгаа, мониторингийн</p>	<p>2021 - 2025</p>			<p>Иргэд, олон нийтэд хог хаягдлын боловсрол олгох сургалт сурталчилгааны ажлыг төрийн байгууллагын зүгээс давхардсан тоогоор 1000 гаруй иргэнд хийж ажилласан. Цэцэрлэгийн багш ажилчдаас бүрдсэн бүрэлдэхүүн нь байгууллагын харьяалах иргэдэд биеэр үлгэрлэн нөлөөллийн ажлыг гүйцэтгэж байна.</p>	<p>90%</p>	<p>50%</p>



1	2	3	4	5	6	7	8	9
	НӨЛӨӨЛЛИЙН ТАЛААРХ ОЛОН НИЙТИЙН ОЙЛГОЛТ, МЭДЛЭГИЙГ НЭМЭГДҮҮЛЭХ	ажлын талаар аймгийн хэвлэл мэдээллийн хэрэгслүүд, интернет хуудас, бүлгүүдтэй нягт хамтран ажиллах						

**“ХОРШООГ ХӨГЖҮҮЛЭХ НИЙГМИЙН ХЭМЖЭЭНИЙ ХӨТӨЛБӨР”  
АЙМГИЙН ДЭД ХӨТӨЛБӨР**

Д/д	Зорилт	Арга хэмжээ	Хэрэгжих хугацаа	Зарцуулсан хөрөнгийн хэмжээ, эх үүсвэр (сая төгрөг)	Зорилтот түвшин, үр дүнгийн үзүүлэлт	Хүрсэн түвшин, үр дүн	Хэрэгжилтийн хувь	Дээд шатны байгууллагын үнэлгээ
1	2	3	4	5	6	7	8	9
1	1. Хоршоодын хөгжлийг бодлогоор дэмжих, хоршоо хөгжих таатай орчинг бүрдүүлэх.	1.1. Төр болон хоршоог дэмжигч байгууллагуудын хамтын ажиллагааг өргөжүүлэн хөгжүүлж үр дүнг нэмэгдүүлэх, Хоршоодын хөгжлийг бодлогоор дэмжих, хоршоо хөгжих таатай орчинг бүрдүүлэх;	2020 - 2024	100000000, Хоршоо хөгжүүлэх сан		Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын 2023 оны 10 дугаар сарын 04-ний өдрийн А/521 дугаар тушаалаар нэмэлт, өөрчлөлт орсон "Хоршоо хөгжүүлэх сангаас хөнгөлөлттэй зээл олгох, сонгон шалгаруулах, эргэн төлүүлэх, хяналт тавих журам"-ыг "Цармын цагаан сувд", "Залаа шинэ-эргэлт", "Залаажинст торгон сүрэг" болон шинээр байгуулагдсан "Сэгс Цагаан Богд" хоршоонд танилцуулж эдийн засгийн үр өгөөжтэй, нийгмийн эрэлтэд нийцсэн, чанартай төслийг Хоршоо хөгжүүлэх сангийн хөнгөлөлттэй зээлд хамруулах боломжтой талаар санал солилцлоо. Хоршоог дэмжигч Тогтвортой ноолуур төслийн хүрээнд "Цармын цагаан сувд" хоршоо нь 42 өрхтэй үүсгэн байгуулагдаж байсан бол энэ онд 76 өрхтэй болон үйл ажиллагаа нь өргөжиж 2020 оноос хойш өөрөө санхүүжилтээ хариуцдаг болж дундын сандаа 83 сая төгрөгийн хөрөнгөтэй, санхүүгийн хувьд биеэ даасан хоршоо болон хөгжсөн. 2023 оны	100%	100%

1	2	3	4	5	6	7	8	9
						байдлаар нийт 1,7 тэрбум төгрөгийн борлуулалт хийсэн байна.		
2	2. Хоршоог хөрөнгө оруулалт, санхүү, зээлийн бодлогоор дэмжиж, өрсөлдөх чадварыг дээшлүүлэх замаар ажлын байр нэмэгдүүлэх	2.1. Хоршоог жижиг дунд үйлдвэрлэлийг хөгжүүлэх сан, сум хөгжүүлэх сан болон орон нутгийн хөгжлийн сангийн хөнгөлөлттэй зээлийн бодлогоор дэмжих	2020 - 2024	100.000.000 төгрөг, Хоршоо хөгжүүлэх сангаас		"Цармын цагаан сувд" хоршооны Залаажинст үүлдрийн цагаан ямааны цөм сүрэг бүрдүүлэх зорилготой "Залаагийн сувд" төсөлд Хоршоо хөгжүүлэх сангаас 2023 оны 8 дугаар сард 40 сая төгрөгийн хөнгөлөлттэй зээл олголоо. 2022 онд "Залаа шинэ эргэлт", "Залаажинст торгон сүрэг" зэрэг 2 хоршоонд Хоршоо хөгжүүлэх сангийн тус бүр 50, 50 сая төгрөгийн хөнгөлөлттэй зээлд хамруулсан.	100%	100%
3		2.3. Хөтөлбөр хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд тусгагдсан хөрөнгийн эх үүсвэрийг аймаг, орон нутгийн жил бүрийн төсөвт тусгаж шийдвэрлэх	2020 - 2024			Сумын Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2022 оны 12 дугаар сарын 16-ны өдрийн хуралдааны "Баянхонгор аймгийн Шинэжинст сумын 2023 оны төсөв батлах тухай" 77 дугаар тогтоолын дөрөвдүгээр хавсралтаар "Хоршоог хөгжүүлэх сан"-гаас 2023 онд 98603100 төгрөгийн зээл олгохоор тусгаж шийдвэрлүүлсэн.	100%	100%



1	2	3	4	5	6	7	8	9
4		2.4. Ашиглагдахгүй байгаа орон нутгийн өмчийн байшин барилга, объектыг хоршоодод үнэ төлбөргүй шилжүүлэх, гэрээгээр эзэмшүүлэх	2020 - 2024			Засаг даргын Тамгын газрын барилгын нэг ерөөнд "Цармын цагаан сувд" хоршоо нь үнэ төлбөргүй байрлан үйл ажиллагаагаа явуулдаг. Тус суманд өөр ашиглагдахгүй байгаа орон нутгийн өмчийн байшин, барилга байхгүй.	100%	100%
5	2. Хоршоогоор дамжуулан түүхий эдийн бэлтгэн нийлүүлэлт, бүтээгдэхүүний үйлдвэрлэл, борлуулалтын сүлжээний оновчтой тогтолцоог бий болгох замаар орон нутгийн хөгжлийг дэмжих.	2.1. Хоршоодыг хөрөнгө оруулалт, санхүү, зээлийн бодлогоор дэмжиж, өрсөлдөх чадварыг дээшлүүлэх замаар ажлын байр нэмэгдүүлэх.	2020 - 2024			"Цармын цагаан сувд" хоршооны Залаажинст үүлдрийн цагаан ямааны цөм сүрэг бүрдүүлэх зорилготой "Залаагийн сувд" төсөлд Хоршоо хөгжүүлэх сангаас 2023 оны 8 дугаар сард 40 сая төгрөгийн хөнгөлөлттэй зээл олголоо. Хяналт тавих орон тооны бус зөвлөл 11 дүгээр сард зээлийн ашиглалт, төслийн гүйцэтгэлтэй танилцахад хоршооны 76 гишүүн өрхөөс Залаажинст үүлдрийн 78 эм ямаа, 2 ухна худалдан авч 2 дугаар багийн малчин Б.Отгонбаатарт хариуцуулан маллуулж ажлын байр нэмэгдүүлсэн байлаа. Нэг малын хариулгын хөлсийг 2000 төгрөгөөр тооцон цалинжуулдаг байна.	100%	100%
6	борлуулалтын сүлжээний оновчтой тогтолцоог бий болгох замаар орон нутгийн хөгжлийг дэмжих.	3.2. Ажлын байр нэмэгдүүлэх болон хөдөлмөр эрхлэлтийг дэмжих санхүүжилтийн тодорхой хэсгийг хоршооны салбарын үйлдвэрлэл, үйлчилгээг дэмжихэд зарцуулах	2020 - 2024	100.000.000, Хоршоо хөгжүүлэх сан		Хоршоо хөгжүүлэх сангаас 2023 оны 8 дугаар сард "Цармын цагаан сувд" хоршооны Залаажинст үүлдрийн цагаан ямааны цөм сүрэг бүрдүүлэх зорилготой "Залаагийн сувд" төсөлд 40 сая төгрөгийн хөнгөлөлттэй зээл олголоо. 2022 онд "Залаа шинэ эргэлт", "Залаажинст торгон сүрэг" зэрэг 2 хоршоонд Хоршоо хөгжүүлэх сангийн тус бүр 50, 50 сая төгрөгийн хөнгөлөлттэй зээлд хамруулсан.	100%	70%

1	2	3	4	5	6	7	8	9
7		3.8. Түүхий эд бэлтгэх, чанарын хамгаалалт, тордолт хийх төвийг хоршооны бүтцэд тулгуурлан сумдад байгуулах	2020 - 2024	Залаа шинэ-эргэлт хоршоо, Цармын сувд хоршоо, Бодиос кашмер хоршоод өөрийн хөрөнгөөр		Тус суманд хэрэгжих боломжгүй тул заалтаас хасуулах саналтай байна.	100%	0%
8		3.9. Хоршоодын үйлдвэрлэсэн бүтээгдэхүүнийг сурталчлах, туршлага судлах зорилгоор дотоодын болон олон улсын үзэсгэлэн худалдаанд оролцуулах	2020 - 2024			"Цармын цагаан сувд" хоршоо нь гишүүн өрхийн нийлүүлсэн ноолуурыг угааж боловсруулан гадаадад сурталчлан нэмүү өртөг шингээн борлуулж энэ онд Франц улсын Hermès групптэй "Бүтээгдэхүүн нийлүүлж гадаадад борлуулах" 3 жилийн гэрээ байгуулсан.	90%	70%
9	3. Хоршооны "Сайн засаглал"-ыг төлөвшүүлэн нийгмийн	3.1. Хоршоогоор дамжуулан түүхий эдийн бэлтгэн нийлүүлэлт, бүтээгдэхүүний	2020 - 2024			"Цармын цагаан сувд", "Баянговь цагаан ямаат" зэрэг хоршоодод ноолуур, "Залаашинэ Эргэлт" хоршоонд арьс, нэхий, ноос, ноолуурыг малчид жил бүр нийлүүлдэг. "Цармын цагаан сувд" хоршоо нь гишүүн өрхийн нийлүүлсэн ноолуурыг угааж боловсруулан гадаадад нэмүү өртөг шингээн борлуулж байна. Гишүүн өрхүүдэд жил бүр ашиг хүртээн ажилладаг.	100%	100%



1	2	3	4	5	6	7	8	9
	үнэлэмжийг дээшлүүлэх.	үйлдвэрлэл, борлуулалтын сүлжээний оновчтой тогтолцоог бий болгох замаар орон нутгийн хөгжлийг дэмжих.						
10		4.1. Хоршооны удирдлага, гишүүдэд зориулсан тусгай хөтөлбөр бүхий байнгын сургалт зөвлөх үйлчилгээг мэргэжлийн байгууллагын оролцоотойгоор үе шаттайгаар явуулах	2020 - 2024	70000, Залаа шинэ-эргэлт хоршоо		Дундговь аймгийн Гурвансайхан суманд 2023 оны 07 сард зохион байгуулагдсан "Хоршоодын шинэчлэл-хөгжлийн шинэ эхлэл" сэдэвт хөдөө аж ахуйн хоршоологчдын улсын зөвлөгөөнд "Цармын цагаан сувд" хоршооны дарга З.Амартүвшин, тогтвортой ноолуур төслөөс Баянхонгор аймагт 2023 оны 11 сард зохион байгуулсан "Хоршооны үнэлгээ, хяналт хийх сургагч багш бэлтгэх" сургалтад "Цармын цагаан сувд" хоршооны нягтлан бодогч Г.Цэдэвсүрэн нар оролцлоо.	100%	100%
11		4.3. Төр засгаас хоршооны хөгжлийг дэмжих чиглэлээр батлан гаргасан бодлогын баримт бичгийг нийтэд танилцуулах, сурталчлах	2020 - 2024			Хяналт тавих орон тооны бус зөвлөлийн бүрэлдэхүүн 11 сард Хоршоо хөгжүүлэх сангийн хөнгөлөлттэй зээлд хамрагдсан "Цармын цагаан сувд" хоршоо, "Бат богд дулаан" ХХК, Ж.Отгонбаяр, Ш.Болормаа, Ч.Булганжаргал нарын зээлийн ашиглалт, бизнесийн үйл ажиллагаатай танилцаж бүтээгдэхүүн, үйлчилгээгээ чанаржуулах, нэмэгдүүлэх, санхүү, төсөв тооцоогоо хянах талаар зөвлөгөө, мэдээллээр хангаж хоршоо хөгжүүлэх сангийн шинэчлэгдсэн журам, Бэст хөтөлбөрөөс эрхлэн гаргадаг жижиг дунд бизнесийн зардлын бүртгэл, гарын авлага материал тараав.	100%	50%
12	3. Хоршооны "Сайн засаглал"-ыг	4.7. Хоршоог дэмжигч шилдэг төрийн түшээг	2020 - 2024			Энэ заалтыг хасуулах саналтай байна.	70%	0%

1	2	3	4	5	6	7	8	9
	төлөвшүүлэн нийгмийн үнэлэмжийг дээшлүүлэх.	сум, аймгийн түвшинд тодруулан өргөмжилж байх						

**ГЭР БҮЛИЙН ХҮЧИРХИЙЛЭЛТЭЙ ТЭМЦЭХ ЭНЭ ТӨРЛИЙН ГЭМТ ХЭРЭГ ЗӨРЧЛӨӨС  
УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ АЙМГИЙН ДЭД ХӨТӨЛБӨР**

Д/д	Зорилт	Арга хэмжээ	Хэрэгжих хугацаа	Зарцуулсан хөрөнгийн хэмжээ, эх үүсвэр (сая төгрөг)	Зорилтот түвшин, үр дүнгийн үзүүлэлт	Хүрсэн түвшин, үр дүн	Хэрэгжил тийн хувь	Дээд шатны байгуул лагын үнэлгээ
1	2	3	4	5	6	7	8	9
1	1. Гэр бүлийн хүчирхийллийн гэмт хэрэг, зөрчлийг бууруулах чиглэлээр төрийн болон төрийн бус байгууллагуудын хамтын ажиллагааг эрчимжүүлэн, урьдчилан сэргийлэх ажлыг үр дүнтэй зохион байгуулж, гэр бүлийн хүчирхийллийн гэмт хэрэг зөрчлийг тодорхой хувиар бууруулсан байх	1.1. Гэр бүлийн хүчирхийллийн гэмт хэрэг, зөрчлийг бууруулах чиглэлээр төрийн болон төрийн бус байгууллагуудын хамтын ажиллагааг эрчимжүүлэн, урьдчилан сэргийлэх ажлыг үр дүнтэй зохион байгуулж, гэр бүлийн хүчирхийллийн гэмт хэрэг зөрчлийг тодорхой хувиар бууруулсан байх	2020 - 2023			Гэр бүлийн хүчирхийллийн гэмт хэрэг, зөрчлийг бууруулах чиглэлээр төрийн болон төрийн бус байгууллагуудын хамтын ажиллагааг эрчимжүүлэн, урьдчилан сэргийлэх ажлыг үр дүнтэй зохион байгуулж, гэр бүлийн хүчирхийллийн гэмт хэрэг зөрчлийг тодорхой хувиар бууруулсан байна зорилтын хүрээнд сургалт нөлөөллийн ажлыг 2 удаа зохион байгуулж нийт 38 өрхийн 67 иргэн хамрагдсан. Дээрх сургалтыг аймгийн Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газраас мэргэжилтнүүд ирж хийсэн бөгөөд иргэдэд хувь зөвлөгөө өгөх нөлөөллийн ажлыг хийж өгсөн.	70%	50%



1	2	3	4	5	6	7	8	9
2	2. Гэр бүлийн хүчирхийллийн гэмт хэрэг зөрчлийг шалган шийдвэрлэж буй эрх бүхий албан тушаалтнуудыг мэргэжил арга зүйн удирдлагаар хангах, Хохирогчдын нууцлал болон аюулгүй байдлын хангаж ажиллах, энэ төрлийн гэмт хэрэг зөрчлийг шалгаж шийдвэрлэх чиглэлээр мэргэшүүлэх сургалтанд үе шаттайгаар хамруулах	2.1. Гэр бүлийн хүчирхийллийн гэмт хэрэг зөрчлийг шалган шийдвэрлэж буй эрх бүхий албан тушаалтнуудыг мэргэжил арга зүйн удирдлагаар хангах, Хохирогчдын нууцлал болон аюулгүй байдлын хангаж ажиллах, энэ төрлийн гэмт хэрэг зөрчлийг шалгаж шийдвэрлэх чиглэлээр мэргэшүүлэх сургалтанд үе шаттайгаар хамруулах	2020 - 2023			Гэр бүлийн хүчирхийллийн гэмт хэрэг зөрчлийг шалган шийдвэрлэж буй эрх бүхий албан тушаалтнуудыг мэргэжил арга зүйн удирдлагаар хангах, Хохирогчдын нууцлал болон аюулгүй байдлын хангаж ажиллах, энэ төрлийн гэмт хэрэг зөрчлийг шалгаж шийдвэрлэх чиглэлээр мэргэшүүлэх сургалтад үе шаттайгаар хамруулах зорилтын хүрээнд аймгийн хэмжээнд зохион байгуулсан 3 удаагийн сургалт зөвлөгөөнд нийгмийн бодлогын мэргэжилтэн, хамтарсан багаар 2 удаа нийт 3 сургалтад амжилттай хамрагдсан.	90%	90%
3	3. Гэр бүлийн хүчирхийллийн улмаас үйлдэгдсэн гэмт хэрэг, зөрчлийн хохирогч болон холбогдогч нарт шаардлагатай тусламж үйлчилгээ үзүүлэх, сэтгэл	3.1. Гэр бүлийн хүчирхийллийн улмаас үйлдэгдсэн гэмт хэрэг, зөрчлийн хохирогч болон холбогдогч нарт шаардлагатай тусламж үйлчилгээ үзүүлэх, сэтгэл	2020 - 2023			Гэр бүлийн хүчирхийллийн улмаас үйлдэгдсэн гэмт хэрэг, зөрчлийн хохирогч болон холбогдогч нарт шаардлагатай тусламж үйлчилгээ үзүүлэх, сэтгэл болон хууль эрх зүйн зөвлөгөө тусламж үзүүлэх таатай орчин бүрдүүлэх хуулиар хүлээсэн үүрэг байгаа боловч төрийн байгууллагын зүгээс байрыг шийдвэрлэх боломжгүйгээр 1 жилийн хугацаа өнгөрсөн. Хүн ам цөөтэй, нэг нэгнээ сайн таньдаг орчин нөхцөлд зөвлөгөө авахаар тусгайлсан тодорхойлсон байр байх тийм чухал биш гэж үзэж байна. Харин үйлчилгээ авдаг төрийн байгууллага	90%	30%



1	2	3	4	5	6	7	8	9
	зүйн болон хууль эрх зүйн зөвлөгөө тусламж үзүүлэх таатай орчин бүрдүүлэх	зүйн болон хууль эрх зүйн зөвлөгөө тусламж үзүүлэх таатай орчин бүрдүүлэх				дотор санаандгүй хэлбэрээр утсаар тохиролцон ганцаарчилсан үйлчилгээг үзүүлэх боломжийг олгож ажилласан. Хууль эрх зүйн болон сэтгэл зүйн зөвлөгөөг ганцаарчилсан байдлаар 12 иргэнд үзүүлж ажилласан. Гэрээр 4 иргэнд үйлчилгээ үзүүлж 300000 төгрөгийн санхүүжилт зарцуулсан.		
4	4. Өсвөр үе, залуучуудад гэр бүлийн боловсрол олгох, гэр бүлийн амьдралд бэлтгэх, гэр бүлийнхээ өмнө хүлээх үүрэг хариуцлага, чадварыг эзэмшүүлэх	4.1. Өсвөр үе, залуучуудад гэр бүлийн боловсрол олгох, гэр бүлийн амьдралд бэлтгэх, гэр бүлийнхээ өмнө хүлээх үүрэг хариуцлага, чадварыг эзэмшүүлэх	2020 - 2023			Өсвөр үе, залуучуудад гэр бүлийн боловсрол олгох, гэр бүлийн амьдралд бэлтгэх, гэр бүлийнхээ өмнө хүлээх үүрэг хариуцлага, чадварыг эзэмшүүлэх аймгийн мэргэжлийн 8 хүн тус суманд ажиллаж сургуулийн өсвөр үеийн 32 сурагч хамрагдсан, ганцаарчилсан сэтгэл зүйн зөвлөгөөг 3 сурагч авч гэр бүлийн боловсрол олгох чиг баримжаа авсан байна.	70%	70%
5	5. Иргэдэд хууль зүйн мэдлэг, эрх зүйн боловсролыг нээлттэй, хүртээмжтэй хэлбэрээр эзэмшүүлэх замаар өдөр тутмын амьдралдаа хэрэглэх чадварыг нэмэгдүүлэх;	5.1. Иргэдэд хууль зүйн зүйн мэдлэг, боловсролыг нээлттэй, хүртээмжтэй хэлбэрээр эзэмшүүлэх замаар өдөр тутмын амьдралдаа хэрэглэх чадварыг нэмэгдүүлэх;	2020 - 2023			Иргэдэд хууль зүйн мэдлэг, эрх зүйн боловсролыг нээлттэй, хүртээмжтэй хэлбэрээр эзэмшүүлэх замаар өдөр тутмын амьдралдаа хэрэглэх чадварыг нэмэгдүүлэх зорилтын хүрээнд Хүний эрхийн түгээмэл тунхаглалын тухай Хөгжлийн бэрхшээлтэй 45 иргэнд, хүний эрхийн талаар 3 багийн 510 иргэнд, 4 багийн нийт 1020 иргэнд ЗДТГ-ын албан хаагчид өөрсдийн ажил үүргийн дагуу хуулийн мэдлэг олгох сургалтуудыг хийж ажилласан. Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн хүний эрүүл аюулгүй орчинд амьдрах эрхийг хангах талаар хуулийн заалтын талаар ойлголт өгөх сургалтыг 324 иргэнд өгч нийт давхардсан тоогоор 1900 иргэнд хууль эрх зүйн чиглэлийг мэдлэг ойлголтыг олгосон байна.	90%	90%



**БАЯНХОНГОР АЙМГИЙН НОГООН ХӨГЖЛИЙН ХЭТИЙН ЗОРИЛТ  
ДУНД ХУГАЦААНЫ БОДЛОГЫН БАРИМТ БИЧИГ**

Д/д	Зорилт	Арга хэмжээ	Хэрэгжих хугацаа	Зарцуулсан хөрөнгийн хэмжээ, эх үүсвэр (сая төгрөг)	Зорилтот түвшин, үр дүнгийн үзүүлэлт	Хүрсэн түвшин, үр дүн	Хэрэгжилтийн хувь	Дээд шатны байгууллагын үнэлгээ
1	2	3	4	5	6	7	8	9
1	ЗУРГАА. ХҮЛЭМЖИЙН ХИЙГ БАГАСГАСАН, БҮС НУТГИЙН БАЙГАЛИЙН НӨӨЦ БАЯЛАГ, СЭРГЭХ ЧАДАВХИД НИЙЦСЭН ДЭД БҮТЭЦ, ХҮН АМЫН СУУРЬШЛЫГ ТӨЛӨВЛӨЖ, ИРГЭДИЙН ЭРҮҮЛ, АЮУЛГҮЙ ОРЧИНД АМЬДРАХ НӨХЦӨЛИЙГ БҮРДҮҮЛНЭ.	6.5. Айл өрх, албан байгууллагын хашаа, нийтийн эзэмшлийн газруудыг цэцэрлэгжүүлэх, зүлэгжүүлэх ажлыг бүх нийтийн хөдөлгөөн болгож, сумын төв, хот, суурин газруудыг ногоон хот болгон хөгжүүлэх бодлогыг хэрэгжүүлэн хувийн хөрөнгөөр тарьж ургуулсан ногоон байгууламж, тарьц, суулгац, ойжуулсан мод, бутыг тарьж ургуулсан	2018 - 2028			Хяналт шалгалтын чиглэлээр: О 3. “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөний хүрээнд: Мод тарих ажлыг эрчимжүүлэх тухай сумын Засаг даргын захирамжийг төлөвлөн гаргуулж, хавар намрын мод тарих аяныг хэрэгжүүлж ажиллалаа. Бүх нийтээр мод тарих ажлыг сумын ойн зурвас газарт зохион байгуулж, нийт 68 иргэн хамрагдан ажиллаж 1500 мод таригдсан. “Сэкер ресорсус” ХХК 1000 суулгац, ерөнхийлөгчийн туслах Даваадалай 850 суулгац өгч мод тарих сонирхолтой иргэдэд тарааж өгөх, модны талбайд нөхөн тарилт хийх зэргээр ногоон байгууламжийг нэмэгдүүлж ажилласан. “Эрдэнэ Монгол” ХХК энэ онд 62000 ширхэг мод үрээр үржүүлсэн байна. Мөн нийгмийн хариуцлагын хүрээнд “Амралтаараа ажиллая” оюутан хөтөлбөр хэрэгжүүлж, 19 оюутан ЗДТГ-ын албан хаагчдад дагалдах ажлыг гүйцэтгэхийн зэрэгцээ мод арчлах, услах ажлыг хийлцэж ажилласан нь ногоон байгууламжийг нэмэгдүүлэхэд тус дэм болсон ажлын нэг байлаа. “Амралтаараа ажиллая” хөтөлбөрийг ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигч “Эрдэнэмонгол” ХХК хэрэгжүүлсэн бөгөөд уг хөтөлбөрт хамрагдсан 19 оюутан залуусыг ногоон байгууламж, мод тарих арчлах ажилд оролцуулж ажилласан. Сумын хэмжээнд 3800 мод таригдсан, 6200 мод үрээр үржүүлсэн бөгөөд энэ онд нийт 10000 гаруй мод тарьсан тоон үзүүлэлттэй байна. Мод тарьсан,	100%	70%

1	2	3	4	5	6	7	8	9
		иргэд, нөхөрлөл, бүлгүүдийг урамшууллын тогтолцоог бүрдүүлнэ.				ургуулсан иргэдийг оны шилдгээр шалгаруулах, урамшуулах төлөвлөлттэй байна.		
2	Долоо. засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийг ногоон хөгжлийн үзэл баримтлалтай, хариуцлагатай, уян хатан, чадавхтай, өндөр бүтээмжтэй, хүнд сурталгүй, иргэдэд төрийн үйлчилгээг ойртуулсан, иргэдээ нийгмийн сайн сайханд хөтөлсөн хөдөлгөгч хүч байхаар хөгжүүлнэ.	7.3. Аймгийн төр захиргааны байгууллага, төрийн өмчийн оролцоотой аж ахуйн нэгжийн худалдан авалтын 20-оос доошгүй хувийг байгаль орчинд ээлтэй, үр ашигтай, хэмнэлттэй бараа, ажил үйлчилгээ худалдан авахад зарцуулна.	2018 - 2028			Байгаль орчинд ээлтэй, үр ашигтай бараа үйлчилгээний зориулалтаар орон нутгийн хөгжлийн сангийн 17500000 төгрөгийн санхүүжилтээр нарны өргүүртэй худгийг мод услах зориулалтаар "Рентек" ХХК суурилуулсан. Мөн байгаль хамгаалах зориулалтаар 2 камер, 1 нөтбүүкийг 6200000 төгрөгөөр худалдан авч ашиглаж байна. Биотехникийн арга хэмжээнд 6500000 төгрөг, газар зүйн нэрийн тодруулга хийх ажилд 10000000 төгрөгийн санхүүжилт зарцуулж Байгаль орчинд ээлтэй үйл ажиллагаанд нийт 43 сая төгрөгийг зарцуулсан байна.	100%	30%

ХЯНАСАН  
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН  
ДАРГА  Л.БАТХУЯГ

БИЕЛЭЛТ ГАРГАСАН  
ХУУЛЬ, ЭРХ ЗҮЙН АСУУДАЛ ХАРИУЦСАН  
МЭРГЭЖИЛТЭН  Г.БАТЧИМЭГ



**ДЭД ХӨТӨЛБӨРИЙН 2023 ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ТОВЧОО**  
(Өөрийн үнэлгээ)

2023 оны 12 дугаар сарын 10

Залаа

ДЭД ХӨТӨЛБӨРИЙН 2023 ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ТОВЧОО			
Хэрэгжилт гаргах нийт арга хэмжээний тоо: 33			
Үүнээс	Үр дүнтэй	<b>100%</b>	<b>13</b>
	Тодорхой үр дүнд хүрсэн	<b>70-90%</b>	<b>20</b>
	Эрчимжүүлэх шаардлагатай	<b>30-50%</b>	-
	Үр дүнгүй	<b>0%</b>	-
	Хэрэгжих хугацаа болоогүй	<b>Х.Б</b>	-
Дэд хөтөлбөрийн жилийн эцсийн хэрэгжилт <b>90%</b> хувьтай байна.			

\_\_\_\_\_ оОо \_\_\_\_\_

**ДЭД ХӨТӨЛБӨРИЙН 2023 ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ТОВЧОО**  
(Дээд шатны байгууллагын үнэлгээ)

2023 оны 12 дугаар сарын 10

Залаа

ДЭД ХӨТӨЛБӨРИЙН 2023 ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ТОВЧОО			
Хэрэгжилт гаргах нийт арга хэмжээний тоо: 33			
Үүнээс	Үр дүнтэй	<b>100%</b>	<b>8</b>
	Тодорхой үр дүнд хүрсэн	<b>70-90%</b>	<b>12</b>
	Эрчимжүүлэх шаардлагатай	<b>30-50%</b>	<b>11</b>
	Үр дүнгүй	<b>0%</b>	<b>2</b>
	Хэрэгжих хугацаа болоогүй	<b>Х.Б</b>	<b>-</b>
Дэд хөтөлбөрийн жилийн эцсийн хэрэгжилт <b>69%</b> хувьтай байна.			

\_\_\_\_\_ оОо \_\_\_\_\_